



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



Говь-Алтай аймгийн  
Дэлгэр сумын ЗДТГ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭР СУМЫН  
НУТГИЙН ЗӨВЛӨЛ



АРХЕОЛОГИЙН  
СУДАЛГААНЫ ТӨВ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ТАЙШИР СУМЫН ЗДТГ



Тайшир

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР  
СУМЫН УЛААНБААТАР ХОТ ДАХЬ  
НУТГИЙН ЗӨВЛӨЛ



ТАЛМЫР ЖИГУУРТАН САЙ

## “ЗАСАГТ ХАН АЙМГИЙН ЭРДЭНЭ БИШРЭЛТ ЗАСАГТ ХАНЫ ХОШУУНЫ ТҮҮХ, СОЁЛ, БАЙГАЛЬ

### ДЭЛГЭР СУМЫН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ АРХИВЫН БАРИМТЫН ТОЙМ

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Угсаатан судлал, биет бус соёлын  
өвийн төвийн эхрэлгч доктор (Ph) Н.Маралмаа

Архивын ерөнхий газрын Сургалт, судалгааны газрын дарга, докторант  
Ч.Оюунчимэг

## ОРШИЛ

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтууд нь эх түүхийн чухаг сурвалж, орон нутаг судлалын тулгуур хэрэглэгдэхүүн болдог. Архивын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны нэг төрөл болох тойм нь архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт баримт болон тодорхой түүхэн үйл явдлын эх сурвалж болох баримтын талаар ерөнхий мэдээлэл өгөх, тэдгээрийн агуулга, бүрэлдэхүүн, байршлыг нээн харуулсан эрдэм шинжилгээний лавлах юм.

Бид энэхүү илтгэлдээ Засагт хан аймгийн Эрдэнэбишрэлт Засагт ханы хошуу, тэр дундаа Дэлгэр сумын түүхэнд холбогдох Манж чин улсын эрхшээлийн үе, Шашин төрийг хослон барьсан хаант Монгол улс, Ардын засгийн үеийн баримтын он цаг, агуулгыг тоймлон танилцуулах, улмаар тухайн баримтыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, олон нийтийн хүртээл болгоход дөхөм болох зорилго тавьсан болно.

Ардын Засгийн газраас эх орны түүхэнд холбогдох баримт, эх сурвалж, ном судрыг нийслэл хүрээнд татан авч, төвлөрүүлэн, улсын мэдэлд авах шийдвэр гаргасны дагуу 1920-иод оны сүүлээс 1940-өөд оны эхэн хүртэлх хугацаанд Манж Чин Улсын эрхшээлийн үе, Шашин төрийг хослон барьсан хаант Монгол Улсын үе болон ардын засгийн эхний жилүүдийн архивын данс хараа, эх сурвалжийг нийслэлд татан авчирсан. Үүний үр дүнд өнөөдрийн Үндэсний төв архивын сан хөмрөг бүрдсэн. Гэвч Их хүрээ буюу нийслэлд ойр байрлалтай Сэцэн хан, Түшээт хан аймаг, Их шавийн баримт харьцангуй бүрдэл сайтай, Нийслэлээс алслагдсан Халхын баруун хоёр аймаг Сайн ноён хан, Засагт хан аймаг, Ховдын хязгаар, Дөрвөдийн хоёр аймаг, Хөвсгөл, Тагна Урианхайн баримт бичгүүд харьцангуй цөөн, бүрдэл муутай байдаг.

## ЗАСАГТ ХАН АЙМГИЙН ЗАСАГТ ХАНЫ ХОШУУ

<b>Манжийн үе (1691-1911)</b>	Халхын өрнө замын Заг голын эх Бидэръяа нуурын чуулганы Эрдэнэ бишрэлт засагт ханы хошуу
<b>Богд хаант Монгол улсын үе (1911-1923)</b>	Засагт хан аймгийн Эрдэнэ бишрэлт засагт ханы хошуу
<b>Ардын засгийн эхний жилүүд (1923-1931 он)</b>	Хантайшир уулын аймгийн Хантайшир уулын хошуу
<b>1931 оны засаг захиргааны өөрчлөлтөөр</b>	Тус хошууны хуучин нутаг нь одоогийн Говь-Алтай аймгийн Тайшир, <b>ДЭЛГЭР</b> , Халиун, Гуулин сумдын нутагт багтан оржээ. (Б.Нацагдорж)
<b>1932 онд орон нутгийн Засаг захиргааны дахин шинэчлэлтээр</b>	Биндэръяа, Өлзийт хоёр сум нэгдэж Дэлгэр сум болжээ
<b>МАХН-ын Төв хорооны удирдамжийн дагуу ХДХГЗ-ны 1959.2.12-ны 14-р шийдвэрээр</b>	Дэлгэр сумыг 2 таслан Дэлгэрэх, Үнээн-Ус сумыг байгуулжээ

### [Засаг ноёдын үе залгамжлал]

Цэвээнжав	Засаг, чин ван	1691-1732
Гэлэгямпил	Засаг, төрийн жүн ван	1732-1741
Балдар	Засаг, төрийн жүн ван	1741-1770
Цэвээнбалжай	Засаг, төрийн жүн ван	1770-1791
Бунираднаа	Засаг, төрийн жүн ван	1791-1823
Маньбазар	Засаг, төрийн жүн ван	1823-1850
Цэрэндэндэв	Засаг, төрийн жүн ван	1850-1877
Доржпалам	Засаг, төрийн жүн ван	1877-1898
Содномравдан	Засаг, төрийн жүн ван	1898-1912
Цэрэнгомбожав	Засаг, төрийн жүн ван	1912-1923

**ДЭЛГЭР СУМЫН ТҮҮХЭНД ШУУД ХОЛБОГДОХ АРХИВЫН БАРИМТ  
ХАДГАЛАГДАЖ БУЙ АРХИВУУД, БАРИМТЫН ОН ЦАГ**

Архивын нэр	Түүхэн үе, он цаг	Баримтын шифр, тоо хэмжээ	Баримтын агуулга	Холбогдох, дэлгэрүүлэн үзэх хөмрөг
Үндэсний төв архивын Түүхийн баримтын архив	Манж чин улсын эрхшээлийн үеийн Халхын өрнө замын Заг голын эх Бидэрьяа нуурын чуулганы Эрдэнэ бишрэлт засагт ханы хошуу	М-193, Д1, ХН 1	Тус хошууны Даашинхүү пүүсэнд төлөх өр төлбөрөө 5 жилд өгч дуусгах тухай нугалбар бичиг /1909, 1/	<b>Засагт хан аймгийн чуулган даргын жасааны хөмрөг М-78</b> , Д1, 1887-1911 он 278 ХН (Тус чуулганаас харьяат хошуудад явуулсан бичгийн хуулга дансууд, хошуудын хил тогтоох, овоо босгох, нэрийг нь шалгах, алба ногдуулсан баримтууд, ган гачиг зудтай холбогдох баримт, <b>Засаг Содномравдангийн хошууны эрийн данс /ХН 208/, Эрдэнэбишрэлт Засагт ханы адуу, тэмээ, үхэр хонь зэргийг бүртгэсэн данс /ХН 268/, Засагт хан ба хошуу ноёдын цалин ХН55).</b>
	Богд хаант Монгол Улсын үеийн Засагт хан аймгийн Засагт ханы хошууны сан хөмрөг 1917	А-190, Д1 ХН 1, ХН 2	Албан хэргээр өртөө, улаагаар дамжигч, элч нарыг тодорхойлсон тухай нугалбар /1917, 2/ Худалдаачдын тээн авчирсан баримт тодорхойлсон бүртгэл /онгүй, 15/	<b>БХМУ-ын Дотоод яамны хөмрөг А-3</b> , Д1-т: Засагт хантай шууд нэр холбоотой 11 баримт байна. Тухайлбал: -Засагт ханы зарим ноёдоос улсын санд тусалсан мал, мөнгө, цаас зэргийг бичсэн тэмдэглэл, 1915, ХН147 -Засагт ханы 10 хошуу хүрээний газар зэвсэг бүхий бүлэглэсэн орос, урианхай хүмүүс ирж, худалдааны иргэдийг хэлмэгдүүлсэн буюу хязгаарыг сэргийлэх цэрэгт буу зэвсэг олгуулах, цэрэг нэмэгдүүлэх 1912, ХН399 -ЗХны хошуудаас ирсэн эр төөлүүр, хүн амын тооны тухай ХН446 -ЗХ ..аймгуудаас сургуульд оруулах хүмүүсийг томилсон, монгол, орос бичиг сургах суралцах хүмүүсийн бүртгэл 1913, ХН 456 -ЗХ-ны чуулган даргаас аймгийн өндөр настныг шагнуулах тухай ирүүлсэн бичиг 1913, ХН 469 -ЗХ... зэрэг 2 аймгийн да, Эрдэнэшанздовын яамнаас залрах замын их гүүрийг засаж сэлбэн сайн болгох гэсэн бичиг 1918, ХН 977
	Ардын засгийн үе Хантайшир уулын аймгийн Хантайшир уулын хошуу	Х-127, Д1	1922-1931 оны 91 ш ХН байна. Ихэнх нь хүн ам, мал, хөрөнгийн бүртгэл байна.	<b>Дотоод яамны хөмрөг Х4, Д1</b> , 1921-1931 Хан тайшир... аймгуудын хурлын тогтоол, 1924.8.15. ХН 305, Хан тайшир уулын аймгийн 5-р хурлын тогтоол, 1928.08.03, ХН 457 Ирсэн, явсан бичгүүд, өргөх цэс, гадаадын харьяат нарын бүртгэл хүн ам, мал хөрөнгийн бүртгэл /671/ <b>Дотоод яамны хөмрөг Х4, Д2</b> , 1921-1931. Хантайшир .... 3 хошуунд хурал удирдуулахаар төлөөлөгч томилсон бичиг (1924.10.26-12.03 ХН 62)

**АРДЫН ЗАСГИЙН ҮЕИЙН ХАНТАЙШИР УУЛЫН АЙМГИЙН ХАНТАЙШИР УУЛЫН ХОШУУ  
/1922-1931/-НЫ БАРИМТЫН АГУУЛГА. Х127, Д1**

№	Баримтын агуулга	Огноо	Барим- тын тоо
1	Хошууны хүн ам, хөрөнгө мал, хурал жасын эд хөрөнгийн бүртгэл	1922, 1924, 1925, 1926, 1927, 1928, 1929, 1931	28
2	Хүн амын боловсрол, мэргэжлийг тодорхойлсон данс, бичиг үсэг мэдэх хүмүүс, сургууль төгсөгчдийн бүртгэл	1926, 1927, 1928, 1929	4
3	Хошуу сумд ба Номонхан хутагтын шавийн хурлын тогтоол данс	1924, 1925, 1926, 1930, 1931	6
4	Гадаадын худалдаачид, гадаад дотоод хүмүүсээс гааль татвар хураасан цэс	1922, 1923, 1928	3
5	Хошуу сумдын төсөв, зарлагын тайлан, татвар	1925, 1928, 1930	4
6	Гадаадын харьяатын бүртгэл	1926, 1928, 1930	3
7	Шүүх, таслах тогтоол, шүүхийн үйл ажиллагаанд холбогдох	1927, 1929, 1930	6
8	Хоригдлуудын бүртгэл, холбогдох баримт	1928, 1930	2+1
9	Хууль дүрэм, бичиг хэрэг, хамтрал, гааль, татвар, түрээс, өр авлага, эрүү, иргэн, зарга тэмцэл, оргодол, хулгай, хоригдол, шорон гэх мэт асуудлаар харилцсан бичгүүд	1926, 1927, 1928, 1929, 1930	19
10	Ирсэн, явсан бичгийн өдрийн тэмдэгт, хуулга данс	1928, 1929, 1930, 1931	7

Зарим онцлох баримтууд:

- Цэцэрлэг Мандалын аймгийн Нар ванчин хутагтын шавьд хавсарсан Самади багш Дилав хутагт Жамсранжавын урд үеийн уг эхийг байцаасан бичиг, 1923 он
- Нутгийн захиргааг шинэчлэн өөрчлөх тухай хурлын тогтоол, санал шүүмжлэл 1930-1931 /Х127-1-84/
- Хошууны ажил байдлыг тодорхойлсон илтгэл 1928

Үзэх: 1, 6, 52, 55, 84

1929 оноос Дэлгэр уул

**Засагт хан аймгийн чуулганы даргад шинэ цутган олгуулах тамганы үсэгт уул аймгийн нутаг Тайшир ханы зэрэг ихээхэн уулын нэрийг оруулан цутгуулбаас нийлэлцэх, үл нийлэлцэх явдлыг заан сургахыг гуйн айлтгасан айлтгал, буулгасан зарлиг. 1912.05.27**

Айлтгах нь.

Шавь боол Цэрэнчимэд, Гомбосүрэн, Цэдэнсоном сөгдөжхичээнгүйлэн айлтгах нь.

Засагт хан аймгийн чуулганы даргад шинэ цутган олгуулах тамганы үсэгт уул аймгийн нутаг Тайшир ханы зэрэг ихээхэн уулын нэрийг оруулан цутгуулбаас нийлэлцэх, үл нийлэлцэх явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж, уламжлан айлтгаад,


Богд эзэн гэгээнээр толилохыг гуйхын учир, эдүгээ сайд, чуулганы дарга Засагт хан Содномравдангаас мэдүүлэн ирсэн бичигт, манай Засагт хан аймгийн чуулганы даргын тамганы үсгийн Заг голын эх Бидэрьяа нуур болбоос Сайн ноён хан аймгийн нутаг болмуй. Хянаваас, бусад аймгийн чуулганы дарга нарын тамганы үсэгт өөр өөрийн аймгийн нутгийн газрын ихээхэн уул ба голын нэр бүхий нь бөгөөд одоо зүй нь шинэ цутган олгуулах тамганы үсэгт уул аймгийн нутгийн ихээхэн уулын нэрийг оруулж цутгуулж нэгэн адил болгохыг хүсэхийн тулд үүнийг Дотоод яамнаа мэдүүлэн явуулаад, байцаан толилж, одоо шинэ цутган шагнан олгуулах, харьяат аймгийн чуулганы даргын тамганы үсэгт уул аймгийн нутаг Хантайшир уул, Ханбуудай уул энэхүү хоёр уулыг Дээр айлтгаж, Зарлигаар нэгийг нь тогтоолгож, оруулан цутгуулж олгуулахыг гуйсугай хэмээн мэдүүлэн иржээ.

Шавь боол Цэрэнчимэд нар хянаваас, Заг голын эх Бидэрьяа нуур бус аймгийн нутаг хэмээн харьяат аймгийн нутгийн дотор бүхий эрхэмхэн уулын нэрд халахыг гуйсан нь ер үл болох газаргүй мэтийн тул хичээнгүйлэн нугалбар бичиж, уламжлан айлтгаад гуйх нь, Богд эзэн гэгээнээр толилж, Хантайшир, Ханбуудай хоёр уулын нэгийг заан гаргаваас болох, эсэх явдлыг заалхийлэн сургах ажааму. Үүний тул хичээнгүйлэн айлтгав. Зарлигийг гуймуй.

*Гуйсан ёсоор болгож, Хантайшир уулын нэрд халагтун. /Мутрын тэмдэг/*

Олноо өргөгдсөний хоёрдугаар он зуны тэргүүн сарын арван хоёр

МУУТА, ТБА, Х.А-173, Д-1, ХН-85, Б.1



Эрдэнэ бишрэлт Засагт хан Содномравдан агсаны хэргэмийг түүний төрсөн ах  
Цэрэнгомбод залгамжлуулах явдлыг айлтгасан айлтгал, буулгасан зарлиг.

1912.07.10

Шавь боол Цэрэнчимэд, Гомбосүрэн, Цэдэнсоном сөгдөж хичээнгүйлэн айлтгах нь.

**Засагт хан аймгийн орон гарсан Засагт хан Содномравдан агсны уг хэргэмийг түүний төрсөн ах Цэрэнгомбод залгамжлуулбаас болох үл болох** явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр толилж, заахийг гуйхын учир. Эдүгээ Засагт хан аймгийн чуулганы даргын газраас харьяат аймгийн Засагт хан Содномравдан өвчнөөр бие баржээ. Эдүгээ түүнд төрсөн хөвгүүнгүй тул төрсөн ах тэргүүн зэрэг тайж Цэрэнгомбо энэ жил гучин зургаан настай, ухаан сэргэлэн, биед өвчин эмгэггүй түүнд Эрдэнэ бишрэлт засагт хан бөгөөд засаг төрийн жүн вангийн хэргэмийг залгамжлуулах эрж, басхүү гэрийн үеийн бичмэлийг хэвээр буулган бичиж, мэдүүлэн хүргэж иржээ.

Үүнд шавь боол Цэрэнчимэд нар хянан байцааваас орон гарсан Эрдэнэ бишрэлт засагт ханы хэргэмийг Содномравдан агсны төрсөн ах тэргүүн зэрэг тайж Цэрэнгомбод залгамжлуулахыг ирсэн нь даруй нийлэлцэхийн тулд гуйсан ёсоор залгамжлуулбаас нийлэлцэх үл нийлэлцэх явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад гуйх нь богд эзэн гэгээнээр толилон заах ажааму. Үүний тул хичээнгүйлэн айлтгав.


Зарлигийг гуймуу.

**Цэрэнгомбожавт Эрдэнэ бишрэлт засагт ханы хэргэмийг залгамжлуулж, гурван нүдэт тогосын отго шагна.**

/Мутрын тэмдэг/

Олноо өргөгдсөний хоёрдугаар он зуны дунд сарын хорин зургаан

МУУТА, ТБА, ХА-173, Д-1, ХН-86, Б.4





Айлтгах нь.

Шавь боол Цэрэнчимэд, Гомбосүрэн, Цэдэнсоном сөгдөж хичээнгүйлэн айлтгах нь.

Зэрэг дэвшүүлэн, хишиг хүртээх явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад,

Богд эзэн гэгээнээр заан айлдахыг гуйх учир, эдүгээ **сайд чуулганы дарга Эрдэнэ бишрэлт Засагт хан Содномравдангаас** манай Дотоод яаманд өргөн мэдүүлсэн бичигт, эдүгээ манай аймгийн түшээ гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Жалцангомбоцэдэнгээс өргөн мэдүүлсэн бичигт, хилс хохирлыг арилгаж, хишиг хүртээхийг мөргөн мэдүүлэх учир, боол Жалцангомбоцэдэн эртнээс эдүгээд хүртэл Очирдара багш Эзэн Богдын өршөөл хишигт хүмүүжсэн аврал итгэлийг сүслэн наманчилж барахгүй, түмэн дор нэгэнтээ хариулан чадсангүй агаад хэтрэмхийлэн хишиг эрсүгэй хэмээх газаргүй, гагцхүү Жалцангомбоцэдэн би уг сурвалжийг нээн хянаваас, Чингис хааны үр Монголын Батмөнх Даян хааны хөвгүүн Гэрсэнз жалайр хунтайжийн зургаадугаар хөвгүүн Далдан хөндлөнгийн үр, язгуурын Халхын найман засгийн нэгэн нь мөн. Урьд Дээд өндөр Богд багш Халх монголчуудыг авч дагаар ороход Жалцангомбоцэдэнгийн уг засаг Цэрэн ахайг засаг төрийн жүн ван өргөмжилжээ. Цэрэн ахай эндэгдэлгүй зүтгэн явж бие барсан атал уг хэргэмийг журамласангүй, мушгихаар зэрэг бууруулж, Ламжавд засаг төрийн бэйл залгамжилжээ. Ламжав үгүй болсон хойно Цэдэнжавд мөн засаг төрийн бэйл залгамжилжээ. Цэдэнжав Манжийн төрд санаа хувьсгаж, тэрслэн явсан учир цаазаар авч, түүний төрлийн дэд зэрэг тайж Норовыг засаг тэргүүн зэрэг тайж болгожээ. Норовоос Жалцангомбоцэдэнд хүртэл долоон үе засаг тайж залгамжлуулсаар ирсэн нь энэ завсраа ял тайлсан газаргүй. Жич, Жалцангомбоцэдэнгийн өвөг эцэг засаг Банзабазаржав цэрэгт туслан явсан учраа үе улиран улсын түшээ гүнгийн зэрэг олгуулжээ. Мэхийж хянаваас, Цэдэнжав болбоос гагцхүү манжийн эрх санааг эс дагаснаас бус уул Монголын дотор хэвийг сахиж явсан нь журмыг огоорсон газаргүй, эдүгээ Эзэн Богд олны зовлонг нигүүлсэн аварч, Эрдэнийн сууринд заларч, Халх Монголын тулгар төрийг байгуулж, цаг дор гамшиг устаж, хүмүүнд гаслан арилж, жаргаланд хөхөлдөн хөгжилдсөн өндөр зузаан тэлсэн хишигт тохиосон учраа, боол Жалцангомбоцэдэнгийн уг урьд Манжийн хаанд буруушаагдсан хохирлыг арилгаж, доорд үнэнхүүг хөгжүүлэн уг хэргэм сурвалжийг илэрхийлэн хишиг хүртээхийг гуйх нь, олдвоос чуулганы дарга Эрдэнэ бишрэлт Засагт хантнаа өргөн мэдүүлээд өршөөн толилж, уламжлан мэдүүлэн айлтгаж, хишиг хүртээхийг сөгдөж мөргөн мэдүүлсүгэй хэмээн өргөн мэдүүлэн иржээ. Хянаваас, энэ нь хэдий он удаасан хэмээвч язгуураас баримталбаас зохих лавдлалтай магад данс тэмдэг бүхий хэрэг бөгөөд жич, басхүү харьяат түшээ гүнгийн зэрэг засаг Жалцангомбоцэдэн болбоос мөн угаас үе улиран улсын түшээ гүнгийн зэрэг бүхий нь сая Эзэн Богд сууринаа сууж, хишиг тархаах зарлиг буулгаж, хан, ван, гүнгүүдэд хэргэм зэрэг нэмж шагнахад **Жалцангомбоцэдэнд үе улиран улсын түшээ гүнгийн зэрэг хэмээсэн нь ер дэвшиж, нэмэгдсэн зүйл үгүй болмуй. Иймийн тул харьяат гүнгийн гуйсан ёсоор уламжлан айлтгаж, түүний уг хэргэм зэргийг илэрхийлж, хишиг хүртээвээс болох ажааму** хэмээх явдлыг олдвоос, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөн мэдүүлээд, байцаан толилж, тогтоон шийтгэхийг гуйн өргөсүгэй хэмээн өргөн мэдүүлжээ. Боолчууд хянаваас, гүн Жалцангомбоцэдэн урьд үед бууруулан долоон үе ял тайлсангүй хэмээвч урьд Чин улсын үед гавьяагаар дэвшсэн ба эндэгдлээр буурсан нь маш олон бөгөөд нэгийг авч хэлэлцвээс бусдыг зогсоохуйяа нэн бэрхийн дээр бүгдийг хэлэлцвээс маш будилаан болох мэт гагцхүү Жалцангомбоцэдэн Чин улсаас үе улиран залгамжлах түшээ гүнгийн 11


зэрэг бүхий бөгөөд эдүгээгийн Хишиг зарлигт зэрэг нэмсэнгүй нь үнэн болохын тулд Жалцангомбоцэдэнд ямар зүйлийн хишиг хүртээх нь Эзнээс гарахын тулд хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад гуйх нь,

Богд эзэн гэгээнээр заан айлдах ажааму. Үүний тул хичээнгүйлэн айлтгав. Зарлигийг гуймуй.

*Жалцангомбоцэдэнд бэйсийн зэрэг шагна. Үе улиран түшээ гүнгийн пүнлүү идүүл, хожим дууриан явахыг зогсоогтун. /Мутрын тэмдэг/*

Олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн сүүл сарын арван хоёр

Эрдэнэ бишрэлт Засагт хан Цэрэнгомбожав тэргүүтэй харьяат хошууны хүн ам, хөрөнгө малын дэлгэрэнгүй бүртгэл (МУУТА, 127-1-1).




1922 оны энэхүү тоо бүртгэлийг Засагт хан Цэрэнгомбожав болон түүний төрөл тайж, туслагч түшмэд тайж, сайд, сум хамжлага гэх мэтээр ангилан нэр, нас, хүйс, хөрөнгө мал, өрхийг нэгбүрчлэн бүртгэсэн.

1922 оноос хойш хүн амыг анги давхаргаар нь ангилан тоолж бүртгэсэн зүйл байхгүй тул энэ бүртгэл нь тайж язгууртан, лам хар хүмүүсийг судлах, ураг удам, гарал үүслийн судалгаа хийхэд чухал баримт болох юм.


“Эрдэнэ бишрэлт засагт ханы хошууны арван хоёр сумын бүх өрх амын данс амой”, 1924 он

МУУТА. ТБА. Х-127, Д-1, ХН-6



1. Эрдэнэ уулын сум /Өмнөд баг, Дундад баг, Хойд баг/
2. Бурханбуудай сум /Өмнөд баг, Дундад баг, Умард баг/
3. Баян-Өндөр сум /Өмнөд баг, Дундад баг, Умард баг/
4. Цэцэрлэг сум /Баруун баг, Дундад баг, Зүүн баг/
5. Чандмань сум /Умард баг, Дундад баг, Өмнөд баг/
6. Тахилгат уул сум /Баруун баг, Дундад баг, Зүүн баг/
7. Бидэрья голын сум /Өмнөд баг, Дундад баг, Умард баг/
8. Өлзийтийн сум /Өмнөд баг, Дундад баг, Умард баг/
9. Дашдаржаа сум /Баруун баг, Дундад баг, Зүүн баг/
10. Наран-Өндөр сум /Өмнөд баг, Дундад баг, Умард баг/
11. Дашинчил сум /Баруун баг, Дундад баг, Зүүн баг/
12. Жаргалант сум /Өмнөд баг, Дундад баг, Умард баг/

Үүнээс дээш 12 сум бүгд өрх 1804, арван гэр 180, багийн тоо 36, **бүх ам 11117**, хуварга лам 1144, нуган хөвгүүд 1819, идэр эр 1724, хөгшин эр 1042, эмс охид 5388 болмуй гэжээ.



# Засагт хан аймгийн Эрдэнэбишрэлт Содонмравдангийн хошууны эрийн данс Хэвт ёсны 3-р он /1911/

Handwritten Mongolian script on a vertical strip of aged, yellowed paper. The text is written in a cursive style, typical of traditional Mongolian manuscripts.

A page of handwritten Mongolian script on lined paper with red horizontal lines. The text is written in a cursive style, typical of traditional Mongolian manuscripts. There are some red markings and a small red stamp at the top.

A page of handwritten Mongolian script on lined paper with red horizontal lines. The text is written in a cursive style, typical of traditional Mongolian manuscripts. There is a prominent red rectangular stamp in the center of the page.

A page of handwritten Mongolian script on lined paper with red horizontal lines. The text is written in a cursive style, typical of traditional Mongolian manuscripts. There is a prominent red rectangular stamp in the center of the page.

“Хантайшир уулын манай хошуунаа суугаа гадаадын хүн нарын нэр тоо, аж үйлдвэр зэргийг тодорхойлсон цэс нь” хэмээх 1928 оны баримтад:

Худалдааны иргэд нь: Орос улсын харьяат Теодор, ...  
үйлдвэрчин иргэд нь: Элдүүрчин Дин Шиян Лин ...  
харьяат хошуунд тахилсан Төвд гачин лам Чүлтэмринчин шавь лам Ванжуур, лам Лхагватүндэв, лам Вандуй, лам Дамдин, лам Сандаг энэ зургаа. Үүнээс дээш нийлсэн гадаадын хүн 85 болмуй гэжээ.


МУУТА. ТБА. Х-127, Д-1, ХН-51

Хантайшир уулын хошууны бичиг мэдэх хүмүүсийг ялган салгаж тодорхойлсон анкет гэх 1928 оны баримтад:

тус хошууны 62 хүн бүртгэгдсэн байх бөгөөд бүртгэлийн 35 дугаарт Арьяагийн Балжир эрэгтэй 44 настай, мөн хошууны Дэлгэр сумын харьяат тайж хар, урьд тушаалгүй явсан, бичихүйд сайн, эх зохиохуйд муу, харилцан туслалцах хорооны нярав идэвх дунд, ам 2 ажилгүй, бүх хөрөнгийн бод 30 малаар, намын 38 дугаар үүрийн гишүүн[1] хэмээн бүртгэгджээ.


Тус баримтад өөр Дэлгэр сумын харьяат хүн бүртгэгдээгүй байна.

[1] МУУТА. ТБА. Х-127, Д-1, ХН-34



Хантайшир уулын хошууны бичиг мэдэх хүмүүсийг ялган салгаж тодорхойлсон анкет гэх 1928 оны баримтад тус хошууны 62 хүн бүртгэгдсэн байх бөгөөд бүртгэлийн 35 дугаарт **Арьяагийн Балжир эрэгтэй 44 настай, мөн хошууны Дэлгэр сумын харьяат** тайж хар, урьд тушаалгүй явсан, Бичихүйд сайн, эх зохиохуйд муу, харилцан туслалцах хорооны нярав идэвх дунд, ам 2 ажилгүй, бүх хөрөнгийн бод 30 малаар, намын 38 дугаар үүрийн гишүүн[1] хэмээн бүртгэгджээ. Тус баримтад өөр Дэлгэр сумын харьяат хүн бүртгэгдээгүй байна.

[1] МУУТА. ТБА. Х-127, Д-1, ХН-34



Харин 1927 онд энэ Балжир нь Чандмань сумын бичиг үсэг мэддэг хүмүүсийн бүртгэлд бүртгэгдсэн байна

**Хан тайширийн хошууны тамгын газрын орон тоо, цалин хэрэглэлийг маягтаар тодорхойлсон нь гэх баримтад**

МУУТА. ТБА. Х-127, Д-1, ХН-71. Х.19-22

№	Албан газрын ба хэлтсүүдийн нэр	19 онд баталсан цалин		19 онд авч авч хаалгасан орон тоо		20 онд төсөвлөсөн буй нь				
		Албан тушаалын нэр		Албан тушаалын нэр		Албан тушаалын нэр				
		тоо	цалин	тоо	цалин	тоо	цалин			
1	Хантайшир уулын хошууны тамгын газрын захирах тушаах хэлтэс	Хошууны дарга	1	81	Хошууны дарга	1	81	Хошууны дарга	1	81
		Эрхэлсэн түшмэл	1	60	Эрхэлсэн түшмэл	1	60	Эрхэлсэн түшмэл	1	60
		Туслах түшмэл	1	51						
		Жинхэнэ бичээч	2	36	Жинхэнэ бичээч	2	36	Жинхэнэ бичээч	2	36
		Зарлага	6	21	Зарлага	5	21	Зарлага	4	21
		Галч	1	21	Галч	1	21	Галч	1	21
		Нэг жилийн дүн	12	4932	Нэг жилийн дүн	10	4068	Нэг жилийн дүн	9	3816
		Эрхэлсэн түшмэл	1	60	Эрхэлсэн түшмэл	1	60	Эрхэлсэн түшмэл	1	60
		Нягтлан бодох түшмэл	1	60	Нягтлан бодох түшмэл	1	60	Нягтлан бодох түшмэл	1	60
		Нягтлан бодох бичээч	1	45	Нягтлан бодох бичээч	1	45	Нягтлан бодох бичээч	1	45
2	Мөн хошууны албан татварын хэлтэс	Жинхэнэ бичээч	2	36	Жинхэнэ бичээч	2	36	Жинхэнэ бичээч	2	36
		Мөнгө барааны нярав	1	45	Мөнгө барааны нярав	1	45	Мөнгө барааны нярав	1	45
		Галч	1	21	Галч	1	21	Галч	1	21
		Нэг жилийн	7	3636	Нэг жилийн	6	3204	Нэг жилийн	6	3204
		Нягтлан бодох бичээч	1	45	Нягтлан бодох бичээч	1	45	Нягтлан бодох бичээч	1	45
		Эрхэлсэн түшмэл	1	60	Эрхэлсэн түшмэл	1	60	Эрхэлсэн түшмэл	1	60
		Нягтлан бодох түшмэл	1	60	Нягтлан бодох түшмэл	1	60	Нягтлан бодох түшмэл	1	60

3	Мөн хошууны цэргийн хэлтэс	Цэргийн хэлтсийн эрхэлсэн түшмэл бөгөөд шүүх таслах газрын нарийн бичгийн дарга	1	60	Цэргийн хэлтсийн эрхэлсэн түшмэл бөгөөд шүүх таслах газрын нарийн бичгийн дарга	1	60	Цэргийн хэлтсийн эрхэлсэн түшмэл бөгөөд шүүх таслах газрын нарийн бичгийн дарга	1	60
		Жинхэнэ бичээч	2	36	Жинхэнэ бичээч	1	36	Жинхэнэ бичээч	1	36
		Галч	1	21	Галч	1	21			
		Нэг жилийн дүн	4	1830	Нэг жилийн дүн	4	1404	Нэг жилийн дүн	2	1152
		Шүүх таслах газрын түшмэл	1	75	Шүүх таслах газрын түшмэл	1	75	Шүүх таслах газрын түшмэл	1	75
		Нарийн бичгийн дарга	1	60	Нарийн бичгийн дарга	1	60			
		Байцаагч	1	60	Байцаагч	1	60	Байцаагч	1	60
		Жинхэнэ бичээч	1	36	Жинхэнэ бичээч	1	36	Жинхэнэ бичээч	1	36
		Гяндангийн дарга	1	25						
		Хуяг	6	21	Хуяг	4	21	Хуяг	4	21
4	Мөн газрын ардын шүүх таслах газар	Нэг жилийн дүн	11	4584	Нэг жилийн дүн	8	3528	Нэг жилийн дүн	7	3060

**тус хошууны 4 хэлтэс, орон тоо, цалин дэлгэрэнгүй тэмдэглэж мөн ирэх онд төсөвлөсөн тухай тэмдэглэжээ.**

**ДЭЛГЭР СУМЫН ТҮҮХЭНД ШУУД ХОЛБОГДОХ АРХИВЫН БАРИМТ  
ХАДГАЛАГДАЖ БУЙ АРХИВУУД, БАРИМТЫН ОН ЦАГ**

<b>Архивын нэр</b>	<b>Түүхэн үе, он цаг</b>	<b>Баримтын шифр, тоо хэмжээ</b>	<b>Баримтын он цаг, тоо хэмжээ</b>	<b>Баримтын агуулга</b>
Үндэсний төв архивын УТНОНБА	Ардын засгийн үе Хантайшир уулын аймгийн намын хорооны хөмрөг	Х10, Д 1	1922-1930 оны 177 ш ХН Намын гишүүдийн бүртгэл, хурлын тогтоол	<ul style="list-style-type: none"> <li>• Хантайшир уулын аймгийн Сутай, Бүрэнтогтох, Наранжаргалант, Жавхлант, Хантайшир сумдын намын гишүүдийн бүртгэл 1926.05.01-1926.07.11 Х4-2-91</li> <li>• Хантайшир уулын аймгийн Наранжаргалант, Тайшир уулын хошуудын Намын үүрийн гишүүдийн бүртгэл 1927.02.27-1927.08.09. 4-2-269</li> <li>• Хантайшир уулын аймгийн Хантайшир уулын хошууны намын гишүүдийн бүртгэл 1928.01.01-1928.01.01. 4-2-492</li> <li>• Хантайшир уулын аймгийн Наранжаргалант, Гурван сайхан жаргалант, Тайшир уулын намын үүрийн намын гишүүд, намд элсэгчдийн бүртгэл 1928.01.01-1928.01.01 4-2-540</li> </ul>

## ДЭЛГЭР СУМЫН ТҮҮХЭНД ШУУД ХОЛБОГДОХ АРХИВЫН БАРИМТ

### ХАДГАЛАГДАЖ БУЙ АРХИВУУД, БАРИМТЫН ОН ЦАГ

Архивын нэр	Хөмрөгийн нэр	Баримтын шифр, тоо хэмжээ	Баримтын он цаг, тоо хэмжээ	Баримтын агуулга
Говь-Алтай аймгийн төрийн архив	Дэлгэр сумын ХДХГ	Хөмрөг № 13	1938-1964, 52 ХН, 306 кг задгай баримт  1973-1980 оны 24 ХН  <b>1991-2008 оны 72 ХН</b>  <b>1938-1992 оны 137 ХН</b>  2021 оны 9 сарын 10-ны байдлаар Данс 3,4,5 нийлээд 61 ХН-тэй байна	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн даргын даалгавар, сумын захиргааны тогтоол, хуралд тавьсан илтэл</li> <li>• уралдааны гэрээ</li> <li>• Багш нарын бүртгэл</li> <li>• Албан татварын тайлан</li> <li>• Сайн малчдын бүртгэл</li> <li>• Эрүүгийн хэргийн материал</li> <li>• Хүн ам, хөрөнгө мал, сумын хогшил, хөрөнгийн бүртгэл, хашаа худгийн бүртгэл</li> <li>• Сумын багийн дарга нарт заах хичээлийн сэдэв бага сургуулийн сурагчдын шалгалтын хүснэгт</li> <li>• ХАА-г хөгжүүлэх жилийн төлөвлөгөө</li> <li>• Сайн малчдын зөвлөгөөнийхурлын материал</li> <li>• Багийн даргын тушаал</li> <li>• Мал өсөлтийн судалгаа, мэдээ</li> <li>• 5 жилийн төлөвлөгөө, биелэлт</li> <li>• сумын 10, 11, 12 дахь удаагийн сонгуулийн чуулганы материал,</li> <li>• захиргааны захирамж, тогтоол, хуралдааны материалууд. Судалгаа</li> <li>• жилийн ажлын төлөвлөгөө, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, түүний биелэлт, тайлан, илтэх хуудас, мэдээ</li> <li>• дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт</li> <li>• мал тооллогын нэгтгэлийн А данс, мал аж ахуйн судалгаа</li> <li>• социалист уралдааны үзүүлэлт биелэлт</li> <li>• АДХГЗ-ны хувьчлалын комиссын үйл ажиллагааны материал</li> <li>• газар эзэмших гэрээ 1, 2-р боть</li> <li>• хүн амын ажил эрхлэлтийн судалгаа, хүн амын тоо, түүнтэй холбогдолтой судалгаанууд, ядуу, нан ядуу өрхийн судалгаа</li> <li>• төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан</li> <li>• сумын 80 жилийн ойн материал, төсөл хөтөлбөр,</li> <li>• НДШ-ийн тайлан</li> <li>• жил, жилийн мал тооллогын дүн...</li> </ul>
	Дэлгэр сумын АДХГЗ	Нийт 5 данстай		
	Дэлгэр сумын , ЗДТГ-ын хөмрөг Дэлгэр сумын нэгдлийн хөмрөг			

# ДЭЛГЭР СУМЫН НЭГДЛҮҮД

Дэлгэр сумын нэгдэл

1. Дэлгэрэх нэгдэл 1957.3.21-ээс
2. Ялалт нэгдэл 1957.04.15-наас 1957.7.26  
1957.7.26 Бадрал нэгдэл  
1958.11.10 Дөл

1959.12.14-өөс:

- Үнээн ус сумын Дэлгэрэх нэгдэл
- Дэлгэр сумын Бадрал нэгдэл

1960.2. Дээрх 2 нэгдлийг нэгтгэн Дэлгэр сумын Бадрал нэгдэл болсон

1960 онд дэлгүүрийн барилга, 1962 онд цахилгаан станц, 1963 онд зочид буудал, гуанз, клуб, 1964 онд сум нэгдлийн конторын шинэ барилгууд ашиглалтанд

оруулсаны дээр 1960 оноос үсчин ажиллаж эхэлсэн байна.

1960 оны жилийн эцсийн тайлан балансаар:

- нийгмийн тэмээ 1433, адуу 4496, үхэр 928, хонь, 37499, ямаа 29161 бүгд 73507 толгой мал
- 721.5 мянган төгрөгийн мөнгөн орлоготой
- 1100.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй
- 1151.7 мянган төгрөгний үл хуваагдах фондтой,
- ГАЗ-51 машин 2-той байжээ.

1960 оны жилийн эцсийн  
тайлан балансаар:

- нийгмийн тэмээ 1433, адуу 4496, үхэр 928, хонь, 37499, ямаа 29161 бүгд 73,507 толгой мал
- 721.5 мянган төгрөгийн мөнгөн орлоготой
- 1100.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй
- 1151.7 мянган төгрөгний үл хуваагдах фондтой,
- ГАЗ-51 машин 2-той байжээ.

2008 оны эцэст 172,797 толгой мал тоолуулсан үүнээс тэмээ 967, адуу 4672, үхэр 1737, хонь 59010, ямаа 106411 толгой байжээ.

# ДҮГНЭЛТ

- Тус сумын хошууны түүхийн судалгааг гүнзгийрүүлэхэд Эрдэнэбишрэлт Засагт ханы хошууны хөмрөгийн баримт хангалтгүй байна.
- Гэсэн хэдий ч тус хошууны хүн амын тооллого, бүртгэл бүрдэл сайтай байгаа бөгөөд цаашид ураг удам, угсааг судлахад чухал эх сурвалж болох баримтууд байгааг онцлон тэмдэглэе.
- Засагт хан аймгийн чуулган даргын газар, тус аймгийн 19 хошууны хөмрөг, БХМУ-ын болон Ардын засгийн Дотоод яамны хөмрөгийн баримтуудаас тус хошууны түүхэнд холбогдох баримт бичгийг илрүүлж, тусгайлан судалж, судалгааны эргэлтэд оруулах улмаар түүхэн тодорхой үеэр нь баримтын эмхэтгэл гаргах нь орон нутаг судлалд чухал ач холбогдолтой байна.
- Дэлгэр сум байгуулагдсанаас хойших баримтууд Говь-Алтай аймгийн архивт харьцангуй бүрдэл сайтай хадгалагдаж байгаа ч данс бүртгэлийг боловсронгуй болгох, баримтын тойм, танилцуулга, эрдэм шинжилгээний лавлахуудыг бичих шаардлагатай байна.

АНХААРЧ  
СОНССОНД  
БАЯРЛАЛАА

***ТАНД АМЖИЛТ  
ХҮСЬЕ***

